



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭЭДЭЭ

№173 /383/

2022.09.28

Цаг үе, үйл явдал

ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ДАДЛАГА, СУРГУУЛЬ БОЛЛОО

Өнөөдөр Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлгийн төлөвлөлтийн баг Монгол Улсын Цэргийн төв эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн үйл ажиллагаатай танилцаж, олныг хамарсан гамшиг, ослын үед яаралтай тусламж үзүүлэх дадлага, сургуулийг үзэж сонирхлоо. Энэ үеэр дараах хүмүүсийн сэтгэгдлийг хуваалцсан юм.

Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлгийн мэс засал, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, хурандаа НИШИЯМА ТИАКАША:

-Манай улс цунами, газар хөдлөлт гэх мэтчилэн байгалийн гамшиг ихтэй тул олныг хамарсан гамшиг, ослын үед яаралтай тусламж үзүүлэхэд ямагт бэлэн байдаг. Монгол Улс яаралтай тусламжийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, чанартай зохион байгуулж чаддаг гэдгийг харуулсан дадлага, сургууль болж өнгөрлөө. Энэ нь ирээдүйд хоёр орон энэ чиглэлээр хамтарсан үйл ажиллагаа явуулахад илүү дөхөм байх болно гэдгийг баталж өглөө.

Япон Улсын Батлан хамгаалах яамны Бодлогын хэлтсийн мэргэжилтэн ЮМИКО ЁШИОКА:

-Япон, Монгол Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, Батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааны 10 жилийн ой тохиож буй энэ үед Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Цэргийн төв эмнэлгийн төлөвлөлтийн баг Монголд айлчилж байгаа нь баяр дээр баяр нэмсэн үйл явдал боллоо. Энэ удаагийн дадлага, сургуулийн гол зорилго нь 2024-2025 онд хэрэгжүүлэхээр зорьж буй Монгол-Японы гамшиг



үйийн тусламж, үйлчилгээ хамтын ажиллагааны төслийн бэлтгэлийг хангах, туршлага солилцох, Монгол Улсын Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагаа, хүчин чадалтай танилцах явдал юм.

Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.ЭНХ-ОД:

-Дэлхийн эрүүл мэндийн салбарт тэргүүлэх үйлчилгээг үзүүлдэг Японы Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлгийн

эмч нарын баг манай эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага солилцох, ирээдүйд хамтарсан томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлыг хэлэлцэж байна. Япон Улс нь гамшигийн үеийн бэлэн байдлыг дээд зэргээр хангасан, мэргэшсэн байдаг. Иймээс бид Японы Цэргийн төв эмнэлгийн туршлага, сургамжийг өөрсдийн цаашдын үйл ажиллагаанд тусган

нутагшуулж, үйл ажиллагаагаа илүү өндөр түвшинд явуулахад анхаарах болно.

Монгол Улс, Япон Улс хоорондын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлгийн бие бүрэлдэхүүн дөрөв хоногийн хугацаанд манай Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.475.00	3.490.0
EUR 🇪🇺	3.415.0	3.440.0
CNY 🇨🇳	479.00	482.00
RUB 🇷🇺	52.70	53
JPY 🇯🇵	24.50	25
KRW 🇰🇷	2.47	2.50

ЗУРХАЙ

2022.09.28 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 3

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ХОЁР ХАР ХӨХ БИЧ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал, баялаг, төгөлдөр болно.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 06.47-18.39

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу.

Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 621,216,675

Эдгэрсэн

Нийт: 601,369,256

Нас барсан

Нийт: 6,542,860

ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙНХЭН ХАМТРАН АЖИЛЛАНА



Монгол Улсын Батлан хамгаалах яам 2014 оноос хойш Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах яамтай хамтран цэргийн салбарын чадавгыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Зэвсэгт хүчний цэргийн инженер, цэргийн эмнэлгийн

мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагажуулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Цэргийн төв эмнэлгийн төлөөлөгчид Цэргийн төв эмнэлгийн

үйл ажиллагаатай танилцахаас гадна холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийлээ. Энэ үеэр БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваатай уулзаж цаашид цэргийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах, олныг хамарсан

гамшиг ослын үед анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хамтарсан дадлага сургууль хийх бэлтгэлийг хангах зэрэг тодорхой чиглэлээр хамтран ажиллахаар тогтов.

Х.УНДАРМАА

Цаг үе, үйл явдал

УРГАЦ ХУРААЛТАД ОРОЛЦОЖ БУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫНХАА БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГААГААР БАХАРХАЖ БАЙНА

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ биелүүлэх бэлэн байдлыг алдагдахгүйгээр эх орныхоо стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, авто замын бүтээн байгуулалт, намрын ургац хураалтын ажилд бодит хувь нэмрээ оруулсаар байна.

Энэ бүхний үр дүнд бид бүхэн нийт ард түмнийхээ чин сэтгэлийн талархлыг хүлээж, Монгол Улсын төр, засаг, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагаас өндөр үнэлэлт авсаар байна.

Түүний дотор Зэвсэгт хүчний зарим бие бүрэлдэхүүн сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу ургац хураалтын ажилд онцгой идэвхтэй оролцоор ирснийг гэрээ байгуулагч компаниудын удирдлагуудаас ирүүлж буй захидал, сэтгэгдэл, гэрээ байгуулах саналуудаас илүү мэдрэгддэг юм.

Өөрөөр хэлбэл, Зэвсэгт хүчний удирдлага болон компани, аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан гэрээний дагуу цэргийн алба хаагчдыг ажиллуулсан компани бүр цаашид тогтвортой гэрээ байгуулах, уг гэрээгээ сунгах саналыг байнга ирүүлж, дараагийн жилүүдэд ч дэмжлэг үзүүлээсэй хэмээн ичээнгүйлэн хүсэж буй нь дээрх мэдрэмжийг улам бүр баталгаажуулж байна.

Энэ өдрүүдэд ЗХЖШ-ын Хөвлөл мэдээллийн албаны дарга болон БХЯ-ны Соёмбо редакцын сэтгүүлчид Төв аймгийн Цээл, Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд газар тариалангийн үйл



ажиллагааг эрхэлж буй компанид гэрээний дагуу ажиллаж буй Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн цэргийн алба хаагчдын ажил, байдалтай танилцаж, сурвалжилга бэлтгэсэн юм.

Бид Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Гантулгын хамтаар дээрх сумдад ажилласан ба биднийг угтаж, ургац хураалтын байдлаа танилцуулсан "Шинэ залуучууд" компанийн Ерөнхий захирал Б.Шагдаржав, "Хатан, Сэлэнгэ, Орхон" компанийн Ерөнхий захирал Б.Үүрцайх нарын хувьд сэтгэгдэл маш өндөр байгаагаа илэрхийлсэн юм.

Тэд "Ургац хураалтын ажилд нэн тэргүүнд тулгамдсан асуудал нь туслах ажилтны дэмжлэг байдаг.

Энэхүү ажилд дэмжлэг үзүүлж буй цэргийн алба хаагчдын хувьд зохион байгуулалт сайн, чин сэтгэлээсээ, шударга хөдөлмөрлөдөг, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааг чанд сахдаг, Хөдөлмөрийн хуульд заасны дагуу зөвхөн ажлын цагт өндөр бүтээмжтэй, үр дүн сайтай ажилладаг. Иймд бид бүхэн ямагт баярлаж, талархдаг нийт тариаланчдынхаа өмнөөс уламжилъя" гэдгийг онцолсон юм.

Хөвлөл мэдээллийн ажилтнууд бид бүхэн тариаланчдынхаа ургац хураалтын ажилд дэмжлэг үзүүлж буй цэргийн алба хаагчдынхаа бүтээлч үйл ажиллагааны талаарх цуврал сурвалжилга, мэдээллийг тус ангийн цэргийн алба хаагчдын бодит жишээн дээр бэлтгэж, Та бүхэндээ хүргэх болно.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ТӨРСӨН ӨДРИЙН ТЭМДЭГЛЭВ



Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан 7, 8, 9 дүгээр сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдынхаа төрсөн өдрийг хамтатган тэмдэглэв.

Төрсөн өдрөөр офицер, ахлагч, хугацаат албаны авьяаслаг дайчдын шигшмэл урлагийн тоглолтыг толилуулж, баяр талархлаа хуваалцаж, мартагдашгүй өнгөрөөж чадсан юм.

Мөн тус ангид хугацаат цэргийн алба хааж байгаа зарим түрүүч, байлдагч нар өөрсдийн хүсэлтээр Зэвсэгт хүчний 150, 331 дүгээр ангиудад цэргийн гэрээт алба хаагчаар улирав. Дэд түрүүч

Б.Гансэлэм, Ж.Найдан нар Зэвсэгт хүчний 150 дугаар ангид, байлдагч Б.Батжаргал, Б.Пүрэвдаш, Н.Төгөлдөр, Н.Буяндэлгэр нар Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид цэргийн гэрээт алба хаагчаар элсэж, ажилдаа шамдан орлоо.

Дэд ахлагч П.Мандахцэцэг (Зэвсэгт хүчний 123 дугаар анги)

Эл өдөр ангай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу.

Хол газар яваар одогсод газар явар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой.

АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан Барилга инженерийн цэргийн хамт олон ахмадуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ.

Хүндэтгэлийн үйл ажиллагаанд Батлан хамгаалахын сайд асан, чөлөөнд байгаа дэслэгч генерал Л.Моломжамц, БЦЕГ-ын дарга, МАА-ын УТГ-ын орлогч, Барилгын цэргийн Улс төрийн хэлтсийн дарга асан, бэлтгэл хурандаа Д.Пүрэвжав, БИЦУГ-ын хэлтсийн дарга, хурандаа Б.Балжинням, ЗХЖШ-ын Ахмадын зөвлөлийн дарга, бэлтгэл хошууч генерал Д.Бадам, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Д.Түмэн, Үйлчилгээний гавьяат ажилтан, бэлтгэл хурандаа С.Сайнцог БИЦУГ-ын удирдлага, үе үеийн ахмадууд оролцлоо.

БИЦ-ийн Ахмадын хорооны дарга, Гавьяат барилгачин, бэлтгэл хошууч генерал П.Доржсүрэн нийт бие бүрэлдэхүүн, ахмадуудад хандан цааш, цаашдын ажил үйлс нь бүтэмжтэй, эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөж үг хэлсэн юм.

Мөн Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгаас Барилга инженерийн цэргийн удирдах газарт залуу халуун нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан ахмадууддаа зориулан уран бүтээлийн дээжээ өргөн барив.



Байлдагч А.ЦОГБАДРАХ: ТӨМС, ХҮНСНИЙ НОГООГ ХУРААН АВАХ АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БУЙДАА БАЯРТАЙ БАЙНА

Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн цөөн тооны цэргийн алба хаагч намрын ургац хураалтын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тэдний нэг байлдагч А.Цогбадрахтай уулзаж ярилцлаа.

Тэр бээр "Би Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж буй Б.Үүрцайх захиралтай "Хатан Сэлэнгэ, Орхон" компани, Н.Алтаншагай захиралтай "Төхөм талын ургац" бүлгийн төмс, хүнсний ногоог хураан авах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаагаа баяртай байна. Би 2018-2021 онд Барилга, технологийн коллежид гагнуурчин мэргэжлээр суралцаж төгссөн. Тус ангид алба хааж буй хугацаандаа цэргийн эрдэмд шамдан суралцсаны зэрэгцээ тэсвэр тэвчээртэй болж, сэтгэл зүй, бие бялдрын хувьд хатуужин төлөвшлөө. Нөгөө талаар би бээр аливаа ажлыг хийх дөртэй болсны хамт нэг ажлыг эхлүүлбэл дуусгасны дараа санаа амардаг хэвшлийг олж авсандаа бэлгэшээж байна. Миний хувьд ургац хураалтын ажилд анх удаа оролцож байгаа. Энэ ажлыг өмнө нь их амархан ажил гэж боддог байлаа.

Байдал өөр бөгөөд маш чимхлүүр ажил юм билээ. Өнгөрсөн хугацаанд төмс, манжин, луван, сонгиныг хураах арга барилыг сайн эзэмшсэнээрээ бахархаж байна. Бид өглөөний 08.00-18.00 цагийн хооронд өдрийн төлөвлөгөөтэй ажилладаг. Энэ хугацаанд өдрийн хоолоо идсэний дараа тогтмол нэг цагийн хугацаанд амардаг юм. Миний хувьд 7 хоногт 3-4 удаа тэрхүү өдрийн төлөвлөгөөт ажлаа давуулан гүйцэтгээд мөнгөн



урамшуулал авдаг. Цөөн тохиолдолд эрт бууж амардаг бөгөөд зарим үед бусдадаа тусалдаг. Ийнхүү бид бүхэн төмс, хүнсний ногоог хураах ажилд оролцож, иргэдийнхээ хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажилд хувь нэмрээ оруулж байгаагаа баяртай байна.

Тэрчлэн бид бүхэн эрүүл агаарт, эко орчинд ажиллахын зэрэгцээ тариалангийн талбайгаас өөрсдөө хураасан шинэ ургацын ногооны дээж бүхий амт чанартай хоолоор дайлуулж байгаагаа талархаж байна" хэмээв.

Хурандаа Б.ОТГОНБАЯР